

**ЦССҮТ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд
хийсэн хяналт шинжилгээний танилцуулга**

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр.

Үнэлгээний зорилго

Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэн жилийн биелэлтэд хяналт үнэлгээ хийж, хүрсэн түвшнийг тогтоох, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг үнэлэх, удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.

Үнэлгээний арга зүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ий өдрийн А/346 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх нийтлэг журмыг тус тус үндэслэн төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний бүтэн жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Хяналт-шинжилгээ

Төв нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Шинээр төлөвлөсөн 15 арга хэмжээ
- 2023 оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй 15 арга хэмжээ
- Тогтмол зохион байгуулдаг 24 арга хэмжээ багтаж байна

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт шинжилгээг хүснэгтээр харуулав.

А) Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал заавар батлах тухай” 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний маягтын дагуу хийсэн үнэлгээ

№	Байгууллага	Зорилтын тоо	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Гүйцэтгэлийн үнэлгээ						Дундаж хувь
				100	95	90	92	82	30	
1.	Төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт		54	48	1	2	1	1	1	97.7%

Үүнийг зорилт бүрээр задалбал:			
Зорилт 1.1.1. Цусны донорын сургалт сурталчилгааг өргөжүүлж донор элсүүлэлтийг нэмэгдүүлнэ.			
3 ажиллагаа төлөвлөсөн	үйл Бүрэн хэрэгжсэн	Тайланг бичилт тодорхой болгох Манай үндсэн ажиллагаанууд хэрэгжилт сайн	
Зорилт 1.1.2. Цусны донор алдаршуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, үр дүнг сайжруулна			
4 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Жил бүр тогтмол хийгддэг хамгийн том үйл ажиллагаанууд сайн хэрэгжсэн байна.	Хамтран ажилласан байгууллагын тоо нэмэгдэж байгаа тоо хувийг эргэн тодруулах
Зорилт 1.1.3. Цусны донорын эрүүл мэндэд учирч болзошгүй хүндрэл, сөрөг нөлөөллөөс сэргийлэх үзлэг, шинжилгээ хийнэ.			
7 үйл ажиллагаа төлөвлөсөн	6 үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн, Нэг үйл ажиллагаа 95% үнэлэгдсэн	Донорын тохойн арчдасын халдваргүйжүүлэх бодисын талаарх судалгаа, улсын бүртгэл, найрлага, хэрэглэх зориулалт зэрэг нэмэлт тодруулга хийх	Шинэ донорт үйлчлэх хэсэг их чухал ч ач холбогдолтой тул хэвшүүлэх тал дээр анхаарах шаардлагатай.
Зорилт 1.2.1. Цахим мэдээллийн сан бүрдүүлж, аюулгүй байдлыг хангана.			
5 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Цахим сүлжээ, программ хангамжтай холбоотой хийсэн зүйл их байгаа тул нэмж тодруулга хийх шаардлагатай ялангуяа дотоод сүлжээн дээр нэмэлт гэрээ хийн сайжруулалт хийгдээд явж байгаа	Хуваалцсан файл дээр саналын дагуу нэмэлт хийх
Зорилт 1.3.1. Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.			
4 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Тайлан бичилт товч оновчтой болжээ.	Заавар зөвлөмжийг цаас болон цахимаар түгээгдсэн мэдээг харах
Зорилт 1.4.1. Технологи шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 100%-д хүргэнэ.			
4 үйл ажиллагаа төлөвлөсөн	1 үйл ажиллагаа давж биелэн нэг нь тодорхой	ЭТИ – аппарат 8-10 дугаар саруудад эвдэрсэн, мөн зэс	Тогтолцооны асуудал шинэ технологийг

	шалтгаанаар 82% байна	ялтасны тасалдлаас гүйцэтгэл дутуу байна	нутагшуулах хүрэлцээтэй төсөвтэй байх
Зорилт 1. 4.2. Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт, олголтод технологийн шинэчлэл хийнэ.			
2 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Хамтарсан төслийн эхний үе шат амжилттай хэрэгжсэн манай талаас хийсэн ажлыг илүү тодорхой болгон ОУ д хэлэлцүүлсэн хурал, хураангуйг нэмж оруулах	ЦЦБ тээвэрлэлтэд дрон ашиглалт хамтын ажиллагаа, шинэлэг асуудал
Зорилт 1.5.1. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн ЦЦБ-ий нөөц хангамж, бэлэн байдлыг хангана.			
2 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Гамшиг онцгой байдлын төлөвлөгөөнд оруулсан тодотгол, БЗД хамтран хэрэгжүүлж байгаа ажлуудыг нэмж тусгах	2025 онд нийтийг хамарсан гамшигийн үеийн бэлэн байдал, дадлага сургуулилалт хийх ажлыг тусгах
Зорилт 2.1.1. Цусны сонор сэрэмжийн тогтолцооны бүртгэл мэдээллийг баяжуулж, дэмжлэгт хяналт үнэлгээ, мэргэжил арга зүйгээр хангана.			
2 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Гүйцэтгэл сайн үйл ажиллагаа	Дэмжлэгт хяналт үнэлгээг цахимаар хийн олон ЦСТ ийг хамруулж, төвийн тасаг нэгж бүр оролцож зөвлөгөө, санал өгөгдсөн сайн талтай.
Зорилт 2.2.1. Лавлагаа шатны тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчийн шаардлагад нийцүүлэн өндөр түвшинд үзүүлнэ.			
2 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Лабораторийн тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр 2 үндэсний чанарын гадаад үнэлгээг амжилттай зохион байгуулж тайланг оролцогчдод хүргэсэн.	НЛТ цөөхөн бүрэлдэхүүнээр сайн зохион байгуулж сэтгэл зүтгэлтэй ажилласан.

Зорилт 2.3.1. Олон улсын болон үндэсний стандартын шаардлагыг тогтвортой хангаж, тасралтгүй сайжруулна.			
3 үйл ажиллагаа төлөвлөсөн.	Бүрэн хэрэгжсэн	Хамгийн сайн хэрэгжсэн үйл ажиллагаанууд шинэлгээр 7014 стандартыг хэрэгжүүлэх ажлын тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн 2025 онд үргэлжлэн хийгдэх ажлууд	Тогтолцооны болон ЭМ-ийн байгууллагын тусламж үйлчилгээнд тавигдах шаардлага стандартуудыг тогтвортой хадгалж байгаа сайн туршлага
Зорилт 3.1.1. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангана.			
1 үйл ажиллагаа төлөвлөсөн	90% гүйцэтгэлтэй	Тайлан шалгууртай нийцүүлж хийсэн ажлыг бүрэн хамруулах	
Зорилт 3.2.1. Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ.			
1 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Азийн цус сэлбэлтийн нийгэмлэгтэй хамтын ажиллагаа сайн хийсэн ажлууд байна	ДХХ хамтран хийгдсэн сургалт, үнэлгээ, хандивын факторын ажлууд нэмж тусгах
Зорилт 3.2.2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлнэ			
2 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Үр дүн ач холбогдлыг нэмж оруулбал их тодорхой болно.	ЭМ судалгаа, үнэдсэний семинар мэт төвийн тогтмол хийдэг үйл ажиллагаа үргэлжилнэ.
Зорилт 3.3.1. Сургалт зохион байгуулж, эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулна			
3 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Шалгуур үзүүлэлт сургалтаа, оролцогч нарын шалгалтын оноо, Сэтгэл ханамж, саналын үр дүнг нэмж оруулах	Ажилтны сэтгэл зүйг дэмжсэн ажил шинэлэг 2025 онд үргэлжлүүлэн улам сайжруулах
Зорилт 3.3.2. Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна.			
3 үйл ажиллагаа төлөвлөсөн	Бүрэн хэрэгжсэн	Шинэчилсэн хөтөлбөрийн багтаамж, нэмэгдсэн зүйлсийг илүү тодорхой болгох	

Зорилт 4.1.1 Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, дотоод хяналтыг сайжруулна.			
4 үйл ажиллагаа төлөвлөсөн	2 үйл ажиллагаа бүрэн, 1 үйл ажиллагаа 92% Нэг үйл ажиллагаа 30% гүйцэтгэлтэй байна.	Бүтэц дүрэм шинэчлэх асуудал, донорын хуулийн шинэчлэлтэй холбоотой хойшлогдоод байна. Төвийн өөрийн зүгээс хийх шинэчлэлтүүд хийгдээд эхний саналууд тусгагдсан хувилбар гарсан байна	Сувилахуйн чадамж шалгуурыг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж улам боловсронгуй болгох шаардлагатай.
Зорилт 4.1.2. Мэдээ тайлан гаргах, нэгтгэх, дүн шинжилгээ хийнэ			
2 үйл ажиллагаа төлөвлөсөн	1 үйл ажиллагаа бүрэн 1 үйл ажиллагаа 90% гүйцэтгэлтэй байна	ЦССҮТ үндэсний хэмжээний ЦА-ны тоо мэдээг тогтмол нэгтгэж, ЭМХТ, ЭМЯ, бүр ОУ-ын байгууллагад илгээдэг тогтсон хэвшсэн үйл ажиллагаа юм.	ЦА үзүүлэлт 2023 ОУ-ын түвшинд хийгдсэн маш чухал шинэлэг ажил болсон
Зорилт 4.1.3. Төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг сайжруулж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ			
1 үйл ажиллагаа төлөвлөсөн.	Гүйцэтгэл 89%	Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа 2 удаа аудит орж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна..	Санхүүгийн тайлант хугацаатай холбоотой гүйцэтгэл одоогоор 89 % байна
Зорилт 4.1.4. Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног, төхөөрөмжийн шалгалт тохируулга баталгаажилтыг тогтмол хийлгэнэ.			
1 үйл ажиллагаа төлөвлөсөн.	Бүрэн хэрэгжсэн.	Тайлагналт нэмж тодруулах Засвар үйлчилгээний нэгдсэн системийн тогтвортой ажиллагааны явц дахь хийгдсэн ажлуудыг нэмж тусгах	Зарим тоног төхөөрөмжийн баталгаат хугацаа дуусаж байгаатай холбоотой нэмэгдэл гарах зардлыг төсөвт майн тусгаж өгөхөд анхаарах

Анхаарах нь:

1. Төлөвлөлт сайжраад байгаа хэдий ч 1 зорилт дотроо хэд хэд задарсан, нийтлэг зорилтыг стратеги төлөвлөгөөтэй уялдуулсан нь ойлгомжгүй байна.
2. Үйл ажиллагааг тодорхой зөв томъёолох дээр анхаарах зарим их том ажлууд нэг дор зарим жижиг ажил бие даасан байдалтай орсон байна.
3. Шалгуур үзүүлэлт оновчтой, хэрэгжилтийг үнэлэхүйц байхад тустай байдлаар илүү сайжруулах
4. Тайланг ойлгомжтой, товч тодорхой шалгуурын дагуу бичигдэхэд анхаарах

Дүгнэлт.


1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан загварын дагуу боловсруулж ЭМЯ, төрийн захиргааны удирдлагын газраас аргазүйн зөвлөгөө авч, бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж хугацаанд нь батлуулж, хэрэгжүүлж ажилласан;
2. Хяналт шинжилгээгээр 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилээр 75%, бүтэн жилээр 97,7,% байна
3. Хийсэн зарим ажлууд дутуу тусгагдсан байгаа тул холбогдох алба, тасаг эргэн харж тодруулга нэмэлт хийх
4. Үйл ажиллагааны гүйцэтгэлийг нотлох материалыг хавсралтаар өгөх. Үйл ажиллагааг төлөвлөсөн дугаараар хавсралтыг оруулбал зохимжтой.

Цаашид авах арга хэмжээ.

1. Хамт олны жилийн хөдөлмөр тул хийсэн ажлыг тайланд бүрэн тусгаж, тодорхой оновчтой байхад, зарим алба тасаг хамт олноор сайн хэлэлцүүлж хэвшихэд анхаарах
2. Ирэх жилийн төлөвлөлтийг ЭМЯ-ны бодлого, төвийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан хамт олноор сайн хэлэлцэж үйл ажиллагааг оновчтой сонгох
3. Манай төвийн дүрэм, стандартад заагдсан үндсэн ажлуудыг төлөвлөгөөнд бүрэн хамруулах тухайлбал: Лавлагаа шинжилгээ, НЭМ-ийн хөтөлбөрүүд гэх мэт
4. Шинэлэг зүйлс, сайн туршлага, дотоод хамтын ажиллагааг сайжруулах НМ-ийн тогтолцооны стандартын 7,4 харилцаа холбоог сайжруулах ажлыг тусгахад анхаарах нь зүйтэй байна.

Энэ үнэлгээг ЦССҮТ ийн Удирдлагын зөвлөлийн 2024 оны 12 сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэв.

ДОТООД АУДИТОР



Т. АЛИМАА